

2016 оны үйл ажиллагааны тайлан

Үндсэн үйлдвэрлэлийн чиглэлээр:

Тавантолгой ХКомпани 2016 онд ТЭЗҮ, УАТөлөвлөгөө, Орон нутгаас өгсөн ерөнхий чиглэлийн дагуу 1 сая тонн нүүрс олборлон борлуулах төлөвлөгөөтэй ажиллаа. 2016 он уул уурхайн салбарт сэргэлт, эргэн ирэлт хийсэн, компанийн үйл ажиллагаа өргөжиж төлөвлөгөөгөө давуулан биелүүлсэн сайхан жил болж өнгөрсөн. Компани 4110.5 мян.тн нүүрс олборлон 4031.5 мян.тн нүүрсийг экспортод, 78.9 мян.тн нүүрс дотоод зах зээлд нийлүүлэн нүүрсний төлөвлөгөөний биелэлт 305,5 хувьтай байлаа. Энэ нь өнгөрсөн онтой харьцуулахад 5,4 дахин илүү борлуулалт хийсэн байна.

2016 онд нийт 11.3 сая м³ хөрс хуулан, 4110.5 мян.тн нүүрс борлуулж, олборлон борлуулахад бэлэн 250,0 мянган тн нүүрсний нөөцтэй байсан. Нийт 14.2 сая м³ уулын цулын ажил гүйцэтгэж, хөрс хуулалтын коэффициентийг 2.7 –той ажиллалаа.

Санхүүгийн чиглэлээр:

Борлуулалтын орлого 176.5 тэрбум төгрөг, үйл ажиллагааны зардалд 111.3 тэрбум төгрөг зарцуулж, 54.04 тэрбум төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажиллаа. Борлуулалтын үйл ажиллагааны үр дүнд улс болон орон нутгийн төсөвт нийт 47.0 тэрбум төгрөгийн татвар хураамж төвлөрүүлсэн байна.

Улс, орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлсэн татвар хураамжийг ангилал тус бүрээр авч үзвэл:

1. АМНАТөлбөрөөр 24,8 тэрбум төгрөг
2. ААНОАТатвараар 16.0 тэрбум төгрөг
3. НӨАТатвараар 1,3 тэрбум төгрөг
4. Агаар бохирдлын төлбөрт 4.1 тэрбум төгрөг
5. ХАОАТатвараар 184,6 сая төгрөг
6. НДаатгалын төлбөрт 471,7 сая төгрөг

Компани 2016 оныг 177 хүний бүрэлдэхүүнтэйгээр 5-н Албадын зохион байгуулалтайгаар ажиллаж ирсэн. Хүний нөөц, сургалтын чиглэлээр төлөвлөгөөт ажлыг 93%-тай хийж гүйцэтгэсэн ба нэн шаардлагатай хүний нөөцийг шинээр авах, мэргэшүүлэн сургах үйл ажиллагааг хийж явууллаа.



Хөдөлмөрийн аюулгүй байдал, Байгаль орчны чиглэлээр:

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны хүрээнд менежментийн төлөвлөгөө боловсруулан ажиллаж 2016 оныг үйлдвэрийн осолгүй жил болгож чадсан. Ажилтан албан хаагчидад журмын дагуу заавар зааварчилгааг өгч ажиллаа. Байгаль орчны чиглэлээр уурхайн өдөр тутмын үйл ажиллагаанд нарийвчлан тусгаж ажилласан. 2017 онд шинээр хийгдэх Байгаль орчны аудит болон дүйцүүлэн хамгаалах арга хэрэгсэлийг хэрэгжүүлэн ажиллах бэлтгэл ажлыг бэлтгэн ажилласан болно.

Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт


2016 онд бизнес төлөвлөгөөнд батлагдсан нийт 4 ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу зохион байгуулан тендер зарлах, харьцуулалт хийх зэргээр нийт 290 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн байна. Мөн түүнчлэн 2016 онд ажилтан албан хаагчдын тав тухтай ажиллах орчныг бүрдүүлэх, хэрэглээний компьютер техник хэрэгсэлээр хангаж ажилласан.

Монгол улсын нүүрсний салбарын мэдээлэл



Компанийн хувьд Монгол улсын нүүрсний экспортын 15%-ийг дангаараа бүрдүүлж коксжих, сул коксжих, исэлдэх ангиллын нүүрсийг тус гадаад зах зээлд борлуулсан.

Сүүлийн 5 жилийн үндсэн үйлдвэрлэлийн график. /мян.тн, мян.м³/



2016 онд нүүрсний гадаад зах зээлд таатай нөхцөл байдал үүсч борлуулалтын хэмжээг нэмэгдүүлэн өнгөрсөн жилүүдээс 5.4 дахин илүү нүүрс олборлон борлуулсан. Мөн энэ нөхцөл байдлыг үндэслэн 1тн нүүрсний үнийг 2.5 дахин нэмэгдүүлж чадсан.

Компанийн нүүрсний борлуулалтын бүтэц

